

ШИД ДОМГИЙН¹ СЭТГЭЛГЭЭГ СУДЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

С.Соёлмаа - Монгол Улсын Боловсролын Их Сургууль, докторант

Түлхүүр үг: Шид домог, өнөөдрийн миф, бүтэц, мифем, зуучлагч, хэлбэр, агуулга, утгат чанар, утгат текст, дискурс

XX зууны Францын хүн судлаач, философич Клод Леви-Стросс, Оросын эрдэмтэн В.Я.Пропп, постструктуралист Ролан Барт нарын бүтцийн мөн чанарыг судалсан байдлыг товч авч үзье. Хэл шинжлэл ба хүн судлал дахь бүтэц шинжлэлийн арга зүйд эсрэг байр суурьтай арга зүй бол формализм² юм. Леви-Строссын байр сууринаас формализм бол биеэ даасан шинжтэй, структурализм бол илүү тодорхой шинжтэй юм. Формалист арга зүйгээс ялгаатай нь структурализм тодорхойг хийсвэрт эсрэгцүүлэхээс, мөн хийсвэрт илүү утга өгөхөөс татгалздаг. Үүнд, хэлбэр нь материйн эсрэг байр сууриар тодорхойлогдож байхад, харин бүтэц бол тусгай агуулга биш, тэр өөрөө бодит байдлын шинж болох логик хэлбэрийн агуулга болж байдаг.

Эрдэмтэн В.Я.Пропп шидэт үлгэрийг бүтэц шинжлэлийн арга зүйгээр судалсан ба шидэт үлгэрийг хоёр хэсэгт хуваасан байна. Үүнд, хэлбэр-бүтэц зүйн (морфология) үндсэн төлөв болох хэлбэр ба тохиолдлын агуулга³ гэсэн хоёр хэсэг байна. Энд Проппын агуулга ба хэлбэр хоорондын ялгаа гарч ирж байгаа юм. Тэрээр хэлбэрийг агуулгаас илүүд үзсэн ба хэлбэрийг мэдрэмжээр хүртэж болно, харин агуулга нь нөлөө бүхий утгаас гадуур үлдэц байдалтай юм гэсэн байна. Харин структурализмын хувьд хэлбэр агуулга хоёрыг сөргүүлэн тавих зүйл байхгүй, зөвхөн тодорхой, эсвэл зөвхөн тодорхойгүй зүйл гэж байхгүй юм. Хэлбэр ба агуулга нь адил мөн чанартай ба аливаа шинжлэлд адил утгаар үйлчлэх ёстой. Агуулга бүтцээс бодит байдлыг олж авдаг бол хэлбэр нь агуулгаас бүтэх жижиг бүтцийг ерөнхий бүтэц рүү оруулах үүрэгтэй юм.

Формализм нь өөрийн судалж буй объектоо устгаж байдаг хэмээн Леви-Стросс шүүмжилсэн байна. Үүний тод жишээг Проппын судалгаанд харж болох ба түүний хувьд үнэндээ ганц л шидэт үлгэр байдаг нь асуудал үүсгэж байгаа юм. Мэдээж нэг хэв шинжит шидэт үлгэр байхгүй, харин тус тусдаа байх олон тооны шидэт үлгэрүүд байдаг гэдэг нь ойлгомжтой ч гэсэн тэднийг яаж ангилах вэ гэдэг нь ойлгомжгүй байгаа юм. Формализмаас өмнө шидэт үлгэрүүд ямар ерөнхий шинжтэй гэдэг нь ойлгомжгүй байхад түүний дараа тэдгээрийг хооронд нь яаж ялгах вэ гэдэг нь бүр ойлгомжгүй болж байна.

Бүтцийн мөн чанарыг тайлбарласан Леви-Строссын тайлбарыг постструктуралист Ролан Бартын тайлбартай харьцуулах нь арга зүйн хувьд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Ролан Бартын үзлээр өнөөдрийн шид домог нь дискрет (тасралтат) шинжтэй⁴,

¹ "Миф"-ийг ердийн үлгэр домгоос ялгаатай учир шид домог хэмээн орчуулсан болно.

² Хэлбэрийг агуулгаас илүүд үздэг үзэл.

³ Пропп В.Я. Морфология сказки. Изд. 2-е. М., 1969

⁴ Ролан Барт. Мифологии. Перевод с французского, вступительная статья и комментарии Сергея Зенкина. М. Издательство им. Сабашниковых. 1996.

өөрөөр хэлбэл түүнийг томоохон хүүрнэл хэлбэрээр илэрхийлэх боломжгүй, дискурс¹ байдлаар илэрхийлж болно. Шид домгийг ярих боломжгүй, харин задлан шинжилж болох юм. Үүнээс эртний болон өнөөдрийн шид домгийн хоорондын мөн чанарын ялгаа гарч ирэх ба Леви-Строссын үзэж буйгаар уламжлалт шид домог нь соёл дахь суурь эсрэгцэлд синтагматик боловсруулалт хийх явдал бөгөөд түүний зорилго нь аливаа зөрчилт зүйлийг шийдвэрлэх логик загварыг бий болгох явдал юм. Иймээс шид домог нь учир холбогдолтой, уран сайхны, зохион байгуулагдсан утгат чанар бүхий найрууламжийг (туульсын, жүжгийн) шаардаж байдаг. Өнөөдрийн шид домог бол зөрчлийг шийдвэрлэх, арилгах үүрэг хүлээхгүй, харин түүнийг шившлэх, зөвтгөх, өөрийн эрхшээлд оруулах үүргийг хүлээдэг. Үйл үгийн бус нэрийн дискурс (энэ нь Бартын "Африкийн дүрэм зүй" хэмээх найруулалд хурц тод тусгалаа олсон байдаг) болохын хувьд шид домог нь Бартын үзлээр "нэр"-ийн домог зүйн соёлтой нягт холбоотой юм. Тэдний олон янз, эмх цэгцгүй, утга санаагүй байдал нь уран сайхны чанарыг нь алдагдуулдаг. Уламжлалт шид домогтой харилцах, түүний тухай ярих гол арга нь туульсын шинжтэй дуу, эмгэнэлт жүжиг байдаг бол орчин үеийн шид домогтой харилцах арга нь шүүмлэлт ЭССЕ байх жишээтэй. Шид домог нь Бартын үзлээр коннотацийн тогтолцоо байдаг. Коннотаци нь хоёрдогч тэмдгийн тогтолцоо бөгөөд түүний анхдагч хэл нь илэрхийллийн ерөнхий төлөвлөгөө болж, харин коннотаци нь өөрөө анхдагч хэлэндээ зориулж шинэ утгыг бүтээдэг байна. Аман бус хэлний коннотациуд нь (мода, ахуйн хэв маяг, жүжиг) энэхүү хэлний дотоод хуулиас төрж гарахгүй, харин аман хэлний илэрхий үйл ажиллагаанаас төрөн гардаг. Юмсыг төөрөгдөлд оруулахгүйн тулд домог зүйч хайж буй шид домгоо юмст өөрт нь шингээж өгөх шаардлагатай. Энэ нь уран зохиолын бүтцийн талаархи Бартын байр суурийг санагдуулна. Түүний үзлээр бүтэц бол ямар нэг хийрхэлийн, хөөрүү шинжтэй, хэрэв түүгээр оролдвол, тэр эргэлзээгүй оршиж байдаг, харин түүнийг үл ойшоовол тэр эс оршино. Бартын хувьд бүтэц бол шид домгийн хувьд хоёрдогч үүргийг гүйцэтгэдэг, нэгэн зэрэг оршдог ба эс оршдог зүйл бол Леви-Строссын хувьд бүтэц бол шид домгийн чухал үүргийг гүйцэтгэдэг ба хосолмол эсрэгцлийн (бинарные оппозиции) зөрчлийг шийдвэрлэх түлхүүр болж байгаа юм.

К.Леви-Стросс шид домгийн бүтцийг шинжлэхдээ, шид домгийн сэтгэлгээний онцлог шинжийг ойлгохын тулд шид домгийг нэгэн зэрэг хэлний гадна ба хэлний дотор орших үзэгдэл хэмээн үзсэн байна. Мөн Ф.Д.Соссюр хэл ба яриа хоорондын ялгааг гаргахдаа хэлийг бие биеэ нөхсөн бүтцийн болон тэнцвэрт гэсэн хоёр хүрээнд авч үзжээ. Шид домог бол "ертөнцийн үүсэл", "цаг хугацааны эхэнд", "эрт урьдын цагт" гэсэн өнгөрсөн үйл явдалд харьяалагддаг. Гэвч шид домгийн жинхэнэ утга нь цаг хугацааны гадна орших, тодорхой агшинд хамаарна.

Шид домог бол яруу найргийн шууд эсрэг зүйл мөн. Яруу найргийг өөр хэл рүү орчуулахад хүндрэлтэй байдаг, түүний аливаа орчуулга нь олон тооны хүндрэлийг дагуулж байдаг. Үүний эсрэг, ямар ч муу орчуулга шид домгийн жинхэнэ үнэ цэнийг арилгаж чадахгүй. Учир нь шид домгийн жинхэнэ мөн чанар нь стиль биш, хүүрнэлийн хэлбэр биш, өгүүлбэр зүй биш, харин яригдаж буй түүх юм. Шид домог бол хэл, гэхдээ

¹ Дискурс (фр. *discours*) өргөн утгаараа- хэлний үйл ажиллагааны үйл явц, яриа. Нийгэм хүмүүнлэгийн утгаараа нийтийн ярианы тогтсон тогтолцоо, мөн цаг хугацааны тодорхой үе дэхь төсөөлөгдөж ангилагдсан бодит байдлын тодорхой зарчим болдог. Дискурс хэмээх үгийн энэхүү утгыг Э.Бенвенист *discours* (яригчид хамаарах яриа) ба *récit* (яригчид хамааралгүй яриа) гэсэн хоёр үгийг эсрэгцүүлэн тайлбарлан шинжлэх ухаанд оруулж ирсэн байна. Энэхүү нэр томъёог семантик, хэл шинжлэлд өргөнөөр хэрэглэдэг.

энэ хэл нь хамгийн өндөр төвшинд илрэх ба түүний хувьд утгат чанар нь хэлний үндсээс ялгарч чаддаг юм.

Ф.Де.Соссюр шид домогт доорхи шинжүүдийг ялган үзсэн байна. Үүнд, 1) хэрэв тэдний зохицон нийлэх арга хэрэгслээр түүний бүрэлдэхүүнд багтах тусгаар элементээр, үзэгдэл, хэлний бүрэлдэхүүн хэсэг; хэл шид домогт хэрэглэгдсэн үедээ л өөрийн онцлог шинжийг олж авдаг; 3) энэхүү онцлог шинжүүд нь хэлний илэрхийллүүдийн жирийн төвшнөөс илүү өндөр төвшинд оршдог, өөрөөр хэлбэл, энэ шинжүүд нь өөр хэв маягийн хэлний илэрхийллийн шинжээс ялгарах илүү нарийн мөн чанартай. Үүнээс хоёр чухал үр дүн гарч байгаа юм. Үүнд, 1) шид домог нь бусад хэл шинжлэлийн объектын адилаар бүрэлдэхүүн нэгжүүдээс бүтнэ; 2) энэ бүрэлдэхүүн нэгжүүд нь хэлний үндсэн бүтэц болох авиалбар, бүтээвэр, утга зүйн нэгжүүдийг илтгэж байдаг; утга зүйн нэгжүүд бүтээвэртэй, бүтээвэр нь авиалбартай харьцдагтай адилаар бүрэлдэхүүн нэгжүүд нь хэлний бүтэцтэй, мөн тийм харьцаанд оршдог. Дараагийн хэлбэр болгон нь өмнөх хэлбэрээсээ илүү өндөр нарийн бүтэцтэй төвшинд оршдог. Энэ шалтгаанаар шид домгийн шинжтэй бүрэлдэхүүн элементүүдийг Леви-Стросс томоохон бүтцийн нэгжүүд буюу мифемүүд хэмээн нэрлэсэн байна. **Мифемүүдийг авиалбар, бүтээвэр, утга зүйн нэгжүүдтэй адилтгаж болохгүй, хэрэв адилтгавал шид домог нь хэллэг илэрхийллээс юугаараа ч ялгарахгүй байх байсан.**

Леви-Стросс, түүний арга зүйгээс өмнө шид домгийн судалгаанд дараахи хандлага байсан гэж үзэж байгаа юм. Үүнд, аливаа шид домгийг бусдаас нь үл хамаарах байдлаар шинжилж байсан бөгөөд хүмүүс үйл явдлын дарааллыг илүү богино өгүүлбэрийн тусламжтайгаар дамжуулахыг эрмэлзэж байсан. Өгүүлбэр болгон хүүрнэл дэхь өөрийн байрт тохирох дэс дараалалд бичигддэг. Үүнээс тохиолдол болгонд үндсэн зүйл нь субъектэд хандах өгүүлэхүүн байдаг гэсэн дүгнэлтэнд хүрч болно. Өөрөөр хэлбэл мифем болгон мөн чанараараа ямар нэг харилцаа байдаг. Энэхүү тодорхойлолт нь хоёр шалтгаанаар хангалттай бус байгаа юм. Нэгдүгээрт, хэл шинжээч-бүтэц шинжээчдийн хувьд бүрэлдэхүүн нэгжүүд нь харилцаа байдаг гэдэг нь илэрхий. Тэгвэл дурын хэлний нэгж болон шид домгийн бүрдэл нэгжүүдийн хооронд ямар ялгаа байна вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Хоёрдугаарт, дээр өгүүлсэн арга нь цаг хугацааны эргэлт буцалтгүй үйл явцыг судалдаг. Шид домгийн цаг хугацааны онцлог шинж болох эргэлт буцалтгүй байдал ба харих чанар, зэрэг цагийн шинж ба цуваа цагийн шинж нь ямар ч нэр тайлбар шаардахгүй зүйл юм. Иймээс шид домгийн бүрдэл нэгжүүд нь тус тусдаа харилцаанууд биш, харин энэхүү харилцаануудын багц байдаг. Энэхүү багцууд зохицсоноор шид домгийн бүрдэл нэгжүүд нь үйл ажиллагааны утгаа олж авдаг. Цуваа хэмжилтэн дэхь нэг багц дахь харилцаанууд нь бие биеэсээ тодорхой зайнд орших бөгөөд хэрэв тэднийг “жам ёсны” зохицолд нэгтгэж чадвал цаг хугацааны хэмжүүрийн шинэ тогтолцоо бий болно. Зэрэг цагийн ба цуваа цагийн гэсэн хоёр хэмжүүртэй энэхүү тогтолцоо нь “хэл ба яриа”-ны онцлог шинжийг өөртөө нэгтгэж байна.

Шид домгийг судлах харьцуулалтын арга (сравнительный метод) нь шид домгийн жинхэнэ зөв хувилбарыг эрж олохыг эрмэлздэгээрээ бүх шид домгийг судлах боломжгүй гэж Леви-Стросс тэмдэглэсэн байна. Домог зүйн судалгааны энэ амжилтгүй байдлын шалтгаан нь юу вэ? Домог зүйн судалгаан дахь агуулгын шинжтэй дүгнэлтүүдийн алдаа нь судлаачид хоёр юмуу гурван хэмжээст тогтолцооноос цааш гарч олон хэмжээсийг ашиглаж чадахгүй байгаад оршино гэж Леви-Стросс үзжээ. Харьцуулсан домог зүй нь уламжлалт эмпирик аргыг олон хэмжээст тогтолцоонд ашиглах боломжгүй учир


математикийг жишиг болгон хөгжих шаардлагатай. Энэ бүхнээс Леви-Стросс шид домгийн бүтцийг дараахи байдлаар математик загварчлалд оруулсан байна. Математик загварчлалыг доорх байдлаар томъёолсон байна. Үүнд, $Fx(a): Fy(b) = Fx(b): Fa^{-1}(y)$.

Леви-Строссын дээрх загварчлалыг эхнэр нөхөр Маранда хэмээх америкийн судлаачид арай товч байдлаар $QS : QR :: FS : FR$ гэж томъёолсон¹ байдаг. Үүнд, QS -квази шийдвэр, харин QR -анхдагч нөхцөл байдлыг илтгэж байдаг квази үр дүн ба түүний шууд үр дагавар, FS -сүүлчийн шийдвэр (зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой эргэлтийн цэг), FR -сүүлчийн үр дүн.

Тэдний үзлээр бүтэц бол ямар нэг бүхэл зүйлийг бүрэлдүүлж, зохион байгуулж буй дотоод харилцаа юм. Бүтцийн шинжлэл нь чухал элементүүдийг олж, улмаар тэдний дотоод зүй тогтлыг олоход оршиж байгаа юм.

Леви-Строссынхоор домог зүйн сэтгэлгээ нь нийгэм-түүхийн баримтуудын хоорондын харилцааны сүлжээг бий болгож инфра, супер тогтолцооны харилцаа хамаарлыг дэмжих бэлгэ тэмдгүүдийн төвшинд үйлчилдэг. Бүтцийн шинжлэл нь текстэд өөрт нь буй эсрэгцлийн хосолмол, тэдгээрийг нэгтгэх зуучлагчийг олоход анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж тэд үзсэн байна.

Леви-Строссын $Fx(a): Fy(b) = Fx(b): Fa^{-1}(y)$ гэсэн томъёоллыг² зуучлагчийн үйл ажиллагааг тусгасан тэмдэглэл хэмээн ойлгож болно. Энэ томъёолол дахь (b) бол – зуучлагч, (a) бол эрч хөдөлгөөнт элементүүдийг илэрхийлэх нийгэм түүхийн контексттэй давхцах анхны нэр томъёо ($f(x)$ функцийг идэвхжүүлэгч), түүний нөлөөн доор үйл явдал өрнөх юм. Эхний функцийн эсрэг $F(y)$ нь (b) –г идэвхжүүлдэг. Тийм янзаар (b) нь ээлж дарааллаар хоёр функцээр идэвхждэг бөгөөд эсрэг гишүүнүүдийн хоорондын зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Түүний эхний гурван гишүүн болох $Fx(a)$, $Fy(b)$, $Fx(b)$ нь хөдөлгөөнт, идэвхтэй үйл ажиллагааг илэрхийлэх бөгөөд, харин $Fa^{-1}(y)$ гэсэн сүүлийн гишүүн нь зуучлах үйл явцын төгсгөл бөгөөд үр дүн эсвэл статус болно. Энэ үйл явцыг ерөнхийд нь дүрсэлбэл эхний байр суурь нь b -ийн үйл ажиллагааны тусламжтайгаар өөрчлөгдөж, энэ өөрчлөлтийн үйл явц нь b -ийн төгсгөлтөй хамт зогсохгүй цааш үргэлжлэх ёстой. Үүнийг дараахи байдлаар дүрсэлж болно.



үүнд, Леви-Строссын харьцуулалтаар бол (b) нь “зүүний сөвөгч”-ийн үүргийг гүйцэтгэж байна, түүгээр нэвт харахад дүрслэл урвуу байдалтай, байгаа байдлаасаа илүү том хэмжээгээр харагдаж байна.

Леви-Строссын энэхүү хувьсал нь, эцсийн үр дүн нь зөвхөн эхний байр сууриндаа эргэж очихоос илүүтэйгээр ямар нэг өсөж томорсон байдалд хүрэх текстийг л хамарч байгаа юм. Зарим текстүүд эсрэгцлийг агуулсан ч гэсэн ямар ч зуучлагчийг өөртөө агуулаагүй байдаг. Энэ тохиолдолд зуучлагч амжилттай үүргээ биелүүлсэн гэж үзэхгүй.

¹ Маранда.П, Кёнгас Маранда.Э. Структурные модели в фольклоре // Структурные модели по семиотике фольклора. М., 1985

² Леви-Стросс. К. Структурная антропология. М., 1983

Үүнээс зуучлагчийн өсөн нэмэгдэж буй хүндрэлийг давж туулах чадвараар нь текстийг дараахи загвараар ангилж болно.

1. Тэг зуучлагч (1-р загвар)
2. Амжилтгүй зуучлагч (2-р загвар)
3. Амжилттай зуучлагч: анхдагч зөрчлийг **арилгагч** (3-р загвар)
4. Амжилттай зуучлагч: анхдагч зөрчлийг **хувьсгагч** (4-р загвар)

Америкийн судлаачид Маранда нарын Леви-Строссын загвараас гаргаж ирсэн зуучлагчийн үүргээр нь текстийг ангилсан дээрх загваруудыг монголчуудын үлгэр, ардын дуу, шидэт үлгэрийн текстэнд задлан шинжлэл хийснээр **шид домог нь үлгэр, аман зохиолоос хэрхэн ялгарах вэ** гэсэн асуудлыг олж болох юм.

Энэхүү шинжлэлдээ үхэл, үзэн ядалт, хорон санаа, буруутай үйлдэл, ер н бүхий л эсрэг утгатай зүйлийг хасах тэмдгээр, харин эерэг утгатай зүйлийг нэмэх тэмдгээр тэмдэглэсэн байна. Тэг зуучлагч буюу 1-р загварын жишээ болгож "Цагаан шаазан" хэмээх монгол ардын дууны текстийг авсан юм. Цагаан шаазанг цавтай байвал цайгаа уухыг болих уу даа, цааз хууль чанганраад байвал, чамтай уулзахыг болих уу даа, ногоон шаазанг цавтай байвал, ногоо идэхийг болих уу даа, ноёдын хууль чангараад байвал, Норов гуйтай уулзахыг болих уу даа, эрээн шаазанг эмтэрхий байвал, идэж уухаа болих уу даа, эзний хууль чангараад байвал, эргэж уулзахыг болих уу даа¹ гэсэн энэ дууны үндсэн бүрэлдэхүүн элементүүдийг доорхи байдлаар дүрсэлж байна.

-	+
Цавтай цагаан шаазан	Бие биедээ хайртай хосууд
Цайгаа уухыг болих	
Чангарсан цааз хууль	
Бие биетэйгээ уулзахгүй байх	
Цавтай ногоон шаазан	
Ногоо идэхийг болих	
Чангарсан ноёдын хууль	
Норов гуайтай уулзахгүй байх	
Эрээн эмтэрхий шаазан	
Идэж уухаа болих	
Чангарсан эзний хууль	
Эргэж уулзахгүй байх	

Үүнийг томъёонд оруулбал а- бие биедээ хайртай хосууд, б- шударга бус ноёдын хууль, эзний хууль цааз, х- уулзахгүй байх, эргэж уулзахгүй байх, у- бие биеэ хайрлах.

$$F_y(a) < F_x(b)$$

Дээрх томъёог дараахи байдлаар уншиж болно. Сөрөг талын функц нь эерэг талын функцийг даван, гарч ирж байна. Товч үгээр хэлбэл, энд зуучлагч байхгүй, учир нь эхний сөрөг байр суурь ерөөсөө өөрлөгдөөгүй байна гэсэн утгаараа энэхүү дууны текст нь нэгдүгээр загварын жишээ болж байна.

2. Амжилтгүй зуучлагч (2-р загвар)

Энхүү хоёрдугаар загвар нь соёлын тогтолцооны контекстэд үүсч буй текстэд илэрч байдаг. Тэдгээрт гол баатар өөрийн үйлдэлдээ амжилтгүй байдлыг үзүүлдэг. Үр дүн нь ихэнхдээ сул хүнийг хүчтэй болгож буй юмсын бүтэлгүй байдлаар илэрлэг.

¹ Монгол ардын дуу. УБ. 1982

Далд хүчний тухай финляндын нэгэн домгийг энэ загварын жишээ болгон авъя.
Нэгэн хахуульд дуртай шүүгч байж гэнэ. Шударга бус шүүгдсэн нэгэн хүн шүүгчийг чөтгөр аваасай гэж хүссэн байна. Шүүгч шөнө дундын үед усанд орохдоо цоргыг онгойлгох гэтэл түүний гарнаас цорго мултарч яаж ч хайсан эргээд олдсонгүй. Ингээд шүүгч нэгэн зарцаа өөр цорго авхуулахаар явуулж гэнэ. Зарцыг эргээж ирэхэд шүүгчийн гэрийн хаалга хаалттай, угаалгын өрөөнөөс ёолох дуу сонсогдов. Яаж ч хичээсэн хаалга онгойсонгүй. Зарц нь санваартанг дуудаж гэнэ. Санваартан ямар ч үйлдэл хийгээд хаалгыг онгойлгож эс чадав. Ар араасаа олон санваартан ирж эцэст нь арван хоёр санваартан ирж хаалгыг онгойлготол, чөтгөр шүүгчийн биеийг хатаагч модон дээр дохоод сүнснийг нь авч одсон байж гэнэ.

Энэ домгийн үндсэн шинжүүдийг дараахи байдлаар үзүүлж болно.

-	+
Шударга бус шүүгч Шударга бус шийдвэр Чөтгөр шүүгчийг авч яваасай гэсэн шүүгдэгчийн хүсэл Чөтгөрийн ялалт	Арван хоёр санваартны шүүгчийг аврах гэсэн оролдлого

Дээрх текстийг томъёонд оруулбал,

- а- шударга бус шүүгч
- б- санваартан, зуучлагч нар

Функц:

х- хараал

у- аврал

$$F_x(a) > F_y\left(\sum_{i=2}^{12} b_i\right)$$

Үүнийг дараахи байдлаар уншиж болно. “Шударга бус явдлыг хараах” гэсэн функц нь зуучлагч-санваартан нарын “аврах” гэсэн функцийг давж гарч байна.

3. Амжилттай зуучлагч: анхдагч зөрчлийг арилгагч

3-р загвар нь текстэд буй зуучлагчийн үйлдэл нь үйл явдлыг хөдөлгөөнд оруулж буй эсрэг үйлдлийг амжилттай сөрсний үр дүнд анхдагч байр сууринд нь оруулж байгаагаар илэрдэг. Үүний тод жишээ болгож, монгол ардын үлгэрийн текстийг авч үзье. Энэ үлгэрийн ерөнхий үйл явдал нь ноёны хүү, баяны хүү хоёр алс хол явж суралцаад буцах замдаа баяны хүү нь ноёны хүүг эрдэмтэй, ухаантайд нь атаархаж чихрүү нь төмөр шааж хороожээ. Үхэхээсээ өмнө ноёны хүү “аваршиг” гэж үгийг хэлээд, танай хүү нас барлаа гэж аавд минь хэлээрэй гэсэн байна. Ингээд баяны хүү энэ үгийг ноёнд хэлтэл ноён энэ үг нь “ариун сайхан нөхөр минь намайг чих рүү төмөр үзэг шааж аллаа” гэсэн үг юм байна гэж мэдээд баяны хүүг хүнгүй зэлүүд, усгүй цөл газар цөлж алжээ. Энэ үйл явдлыг шинж байдлаар нь ангилбал

-	+
Баяны хүү ноёны хүүг хороосон нь	Ухаантай ноёны хүү
	Үнэн явдал ялсан нь

Томъёо байдлаар дараахи байдлаар илэрхийлж болно.

- а- Атаархуу баяны хүү
- б- Ухаантай ноёны хүү-зуучлагч
- х- баяны хүүгийн хорт үйлдэл
- у- үнэн явдал ялсан нь

$$fx(a):fy(b)::fx(b):fy(\bar{a})$$

Дээрх томъёог дараах байдлаар уншиж болно. Хэрэв баяны хүүгийн тэнэг мунхаг үйлдэл нь ухаант ноёны хүүг хорооход хүргэж байгаа бол ноёны хүүгийн ухаант үйлдэл нь баяны хүүгийн хорон санааг илчилж байна.

4. Амжилттай зуучлагч: анхдагч зөрчлийг хувьсгагч (4-р загвар)
Дөрөв дэхь загварын текстэд зуучлах үйл явц нь анхдагч зөрчлийг арилгаад зогсохгүй, мөн энэхүү зөрчлөөс ямар нэг давуу талыг олж хардаг. Зуучлагчийн хүчийг нөхөж байсан зүйл нь төгсгөл хэсэгт биелэгддэг. Ийм загварын текстэд анхдагч гишүүний соёлын утга нь улам хүчирхэгжих бөгөөд түүний эсрэг хүчнийхээ өмнөөс эсэргүүцэх чадвар нь түүнд өөрийн хүч чадлаа, давуу талаа улам сайжруулах бололцоо олгодог. Үүний жишээ болгож дараахи оньсгын бүтцийг авч үзье.

Нүд байна, харин харж чадахгүй. Тэр юу вэ?

- а- нэг утгат нүд
- б- олон утгат нүд
- функц нь:
- х- харж болно
- у- харж болохгүй

$fx(a) : fy(b) :: fx(b) : fa^{-1}(y)$ гэсэн томъёог уншихдаа нэг утгат нүд харж чаддаг, олон утгат нүд ч гэсэн харж чадна. Тиймээс эцсийн үр дүнд “нүдний” хоёрдмол шинжтэй утга нь “харж чадахгүй” гэснийг нөхцөлдүүлж байна.

Хэрэв “Хардаггүй” гэдэг нь нүдний өөр нэг зүйрлэл болж байгаа бол оньсгын дүр нь томъёоны эхний гурван гишүүнд хамаарч, харин хариулт нь сүүлийн гишүүнд харьяалагдана. Учир нь хариулт нь ойлголтын нэг утгат байдлыг зөрчихөд сөрших бөгөөд зүйрлэсэн тайлбар шинжтэй дурын хариулт нь зөв байх юм. Үүнээс дүгнэхэд энэ оньсгонд янз бүрийн хэл дээрх янз бүрийн хариултыг өгч болно. Харин энэхүү хариулт нь “нүд” гэдэг үгний зүйрлэсэн утгыг өгч байх ёстой. Ийм төрлийн оньсгууд нь үнэхээр интернациональ шинжтэй юм. Тухайлбал, явж чаддаггүй хөл; сонсож чаддаггүй чих; хөлгүй мөртлөө гүйдэг гэх мэтчилэн оньсгууд олон зан заншилд тааралддаг. Энэ оньсгын зуучлагч нь нүдний ямар ч дурын утгыг илэрхийлж чадах ба харах, харахгүй гэсэн хоёр үүрэгтэй “нүд” гэсэн ойлголт юм.

Ингээд аман зохиолын бүтцийг задлан шинжилсэн байдлаас дүгнэн хэлэхэд Леви-Строссын шид домгийн бүтцэд хийсэн томъёоллын нууц нь ялангуяа сүүлийн дөрөвдөх загвар дээр тайлагдаж байгаа бөгөөд шид домгийн зуучлагч гэдэг бол аливаа зөрчлийг арилгаад зогсохгүй, зөрчлийн эхний байдлыг орвонгоор нь эргүүлж шинэ утга, шинэ тогтолцоог бий болгох үүргийг хүлээж байдаг. Өөрөөр хэлбэл, зуучлагчийн үүрэг нь зөрчлийг шийдвэрлэхээр хязгаардагдахгүй, зөрчлөөс үүсэх өөр зөрчлийг, мөн өөр утгыг нээхэд оршиж байна.

Аливаа текстийн хүрээнд ил утгаас гадна далд утга ихээхэн үүргийг эзэлдэг бөгөөд түүнийг нээн илрүүлэх нь аливаа утгын оршин байх үндэс нь болдог билээ. Энэхүү өгүүлэлдээ бүтэц задлан шинжлэх арга зүйн эцэг хэмээн нэрлэгддэг францын хүн судлаач, философч К.Леви-Строссын шид домгийн сэтгэлгээг судлах арга зүйн нэг чухал санааг тайлбарлах оролдлого хийлээ. Ахуйн гэр орон нь хэл хэмээн германы философч

М.Хайдегер нэгэнтээ хэлсэн байдаг. Хэл гэдэг бол хүний өөрийн оршихуйн жинхэнэ утгыг нээн илрүүлэх, өнгөрсөн, одоо, ирээдүйн холбоос болдог тэрхүү утгат ба утгаас гадна орших ахуйн гэр орон нь билээ. Тэр дундаа шид домог нь аливаа үндэстэн соёлын оршин тогтнох арга хэрэгсэл, дээд төвшний хэл, утга, үнэлэмжийн тулгуур болдог тул соёл судлаач, хүн судлаач, угсаатан судлаач, философч нарын хувьд шид домгийн сэтгэлгээг судлах бүтэц шинжлэлийн арга зүй нь чухал ач холбогдолтой гэдэг нь ойлгомжтой.

Ишлэл авсан бүтээлүүд

1. *Леви-Стросс К.* Структурная антропология. М., 1983.
2. *Леви-Стросс К.* Структура мифов. – ВФ. 1970, №7.
3. *Леви-Брюль Л.* Первобытное мышление. М., 1930.
4. *Михайлова Г.* Монгольские сказки. М., 1962.
5. *В.Я. Пропп.* Морфология сказки. Изд. 2-е. М., 1969, с. 138.
6. *Мелетинский Е.М.* Поэтика мифа. М., 1976.
7. *Мелетинский Е.М., Неклюдов С.Ю.* Зарубежные исследования по семиотике фольклора. М., 1985.
8. *Михайлов Г.И.* Песни аратов. М., 1973.
9. *Неклюдов С.Ю., Рифтин Б.Л.* Новые материалы по монгольскому фольклору. – Народы Азии и Африки, 1976 № 2.
10. *Пропп В.Я.* Морфология сказки. Изд. 2-е. М., 1969, с. 138.
11. *Ролан Барт.* Мифологии. Перевод с французского, вступительная статья и комментарии Сергея Зенкина. М. Издательство им. Сабашниковых. 1996.
12. *Маранда.П., Кёнгас Маранда.Э.* Структурные модели в фольклоре // Структурные модели по семиотике фольклора. М., 1985.
13. Монгол ардын дуу. УБ. 1982
14. www.wikipedia.ru